




“СИМПЛ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346; info@uaf.mn

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл.....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл.....	5
4. Татан буугдах үйл ажиллагааны тухай.....	7

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

“Симпл Ассет ТЗК” ХХК нь 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд “Ашид Капитал ББСБ” ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

“Симпл Ассет ТЗК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Д.Баярсайхан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Э.Сэлэнгэ, ТУЗ-ийн хараат гишүүнээр Б.Тэмүүлэн нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК ажилласан.

“Симпл Ассет ТЗК” ХХК нь 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр 50 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Симпл Ассет ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011838466
Регистрийн дугаар	6852688
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/06/08
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	309
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	500,000
ХБҮЦ (сая төг.)	50,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	15.0%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь 2023 онд ХБҮЦ-ны үндсэн төлбөрт 50.00 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 5.62 тэрбум төгрөгийг төлсөн бөгөөд ХБҮЦ-ны хугацаанд 6 удаагийн хүүгийн төлбөр болон 2 удаагийн үндсэн төлбөрт нийт 59.38 тэрбум төгрөгийг доорх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулаад байна.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2022/09/23	50,000,000,000.00	-	1,890,410,958.90
2	2022/12/23	50,000,000,000.00	-	1,869,863,013.70
3	2023/03/23	50,000,000,000.00	-	1,849,315,068.49
4	2023/06/23	50,000,000,000.00	25,000,000,000.00	1,890,410,958.90
5	2023/09/25	25,000,000,000.00	-	945,205,479.45
6	2023/12/25	25,000,000,000.00	25,000,000,000.00	934,931,506.85
Нийт			50,000,000,000.00	9,380,136,986.30

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны сүүлийн үндсэн төлбөр төлөхтэй холбоотойгоор 11.81 тэрбум төгрөгийн дүн бүхий хөрөнгийн багцын үлдэгдлийг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдсан. Улмаар 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ХБҮЦ-ны сүүлийн төлбөрийг хуваарийн дагуу амжилттай төлж барагдуулаад байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.12.31	2023.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	41,371,590,954.34	-	-100.0%
Зээлийн дундаж үлдэгдэл	2,757,003.26	-	-100.0%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.05%	-	-100.0%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	0.45%	-	-100.0%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	24.44%	-	-100.0%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	8.16	-	-100.0%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	12.18	-	-100.0%
Сарын дундаж төлбөрийн дүн	310,464.47	-	-100.0%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	2,388,048.70	-	-100.0%
Зээлийн тоо	15,006	-	-100.0%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	-	-100.0%
Чанаргүй зээлийн хувь	2.73%	-	-100.0%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	48,643,579,449.19	118,847,468,797.08	
Зээлийн үндсэн төлбөр	43,143,748,959.84	106,888,405,916.68	
Хүүгийн төлбөр	5,494,656,937.35	11,919,542,799.51	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	5,166,035.00	39,520,080.89	

ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд ХБҮЦ-ны төлбөрийг төлж дууссантай холбоотойгоор 2023 оны жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 0.00 төгрөг, харилцах дансны үлдэгдэл 9.3 сая төгрөг байна.

Тайлан хугацаанд “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь “Симпл Ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	23,018	-
2	Багцад нэмж бүртгэсэн	12,458	18,954,357,061.70
3	Буцаан шилжүүлсэн	4,633	11,806,508,288.48
	Нийт	40,109	30,760,865,350.18

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Симпл Ассет ТЗК” ХХК-ийг “Ашид Капитал ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Ашид Капитал” ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 01/1317 тоот шийдвэрээр Д.Баярсайхан, Б.Тэмүүлэн, Э.Сэлэнгэ нарын ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Д.Баярсайхан ТУЗ-ийн даргаар томилсон. 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 01 тоот шийдвэрээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг компани татан буугдах хүртэл хугацаатайгаар улираан томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 4 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.01.10	Санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталгаажуулах тухай	2022 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж 2023 оны 01 сарын 10-нд СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
2	2023.03.16	Хадгаламж нээх гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтныг томилох тухай	Капитрон, Тээвэр хөгжлийн банк болон М банкинд хадгаламжийг данс нээлгэх улмаар захиран зарцуулах эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захиралд олгов.
3	2023.04.06	Жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэж санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хангалттай гэж дүгнэв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарлан хуралдуулав.
4	2023.04.11	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталгаажуулах тухай	2023 оны 1 дүгээр улирлын Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
5	2023.07.19	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталгаажуулах тухай 2023 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг баталгаажуулах тухай	2023 оны 2 дугаар улирлын Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн. Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг зөвшөөрч, батлав.
6	2023.10.10	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталгаажуулах тухай	2023 оны 3 дугаар улирлын Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталж СЗХ, МХБ болон хөрөнгө

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
			оруулагч нарт хүргүүлсэн. 2023 оны 2 дугаар улирлын Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
7	2023.12.22	Хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай Хувьцаа эзэмшигчийн хурал зарлан хуралдуулах тухай	Хөрөнгийн багцыг буцаан худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов. Хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулав.

4. Татан буугдах үйл ажиллагааны тухай

“Симпл Ассет ТЗК” ХХК нь ХБҮЦ-аар хүлээсэн үүргээ 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөр бүрэн гүйцэтгэсэн тул ХБҮЦ-ны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтыг үндэслэн ХЭХ-ийн 2023 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 02 тоот шийдвэрээр компанийг татан буулгахаар шийдвэрлсэн.

Тус шийдвэртэй холбоотойгоор 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/42 тоот бичгээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу “Симпл Ассет ТЗК” ХХК-ийг татан буулгах шийдвэрийн талаар улсын бүртгэлийн газарт мэдэгдэж, СЗХ-оос ТЗК-ийг татан буулгахтай холбоотой зөвшөөрөл авахаар ажиллаж байна.

СЗХ-оос ТЗК-ийг татан буулгах зөвшөөрөл гарсны дараа холбогдох бусад үйл ажиллагаа хийгдэнэ.